



МОНГОЛ УЛС
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 03 сарын 20 өдөр

Дугаар А/129

Мандалговь

Сумдын Засаг дарга, Засаг даргын
Тамгын газрын 2022 оны үйл
ажиллагааны үр дүнгийн тухай

Монгол улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 60.1.17, 66.1, Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын 9.5, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалаар батлагдсан “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 2.1.6, Аймгийн Засаг даргын 2017 оны А/452 дугаар захирамжаар баталсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх журам”-ын 12.1, 12.2, 12.5, дахь заалт, аймгийн Засаг даргын зөвлөлийн хурлын 2023 оны 03 дугаар сарын 16-ны өдрийн 03 дугаар хуралдааны тэмдэглэлийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Сумын Засаг дарга, Засаг даргын Тамгын газрын 2022 оны үйл ажиллагааны үр дүнд хийсэн хяналт-шинжилгээ үнэлгээний нэгдсэн дүнг нэгдүгээр хавсралтаар, хяналт шинжилгээ, үнэлгээний мөрөөр сумдад нийтлэг хэрэгжүүлэх зөвлөмжийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Аймгийн Засаг даргын зөвлөлийн хурлаас тэмдэглэлээр өгсөн нийтлэг зөвлөмжийг хэрэгжүүлэх төлөвлөгөө боловсруулан хэрэгжүүлж сум, байгууллагын үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэн ажиллаж, зөвлөмжийн хэрэгжилтийг 6, 11 сарын 10-ны өдрийн дотор Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтэст тайлагнаж ажиллахыг сумдын Засаг дарга, Засаг даргын Тамгын газрын дарга нарт үүрэг болгосугай.

3. Жилийн үйл ажиллагааны үр дүнгээр “Санаачилгатай сайн” үнэлэгдэж тэргүүн байр эзэлсэн Эрдэнэдалай сумын Засаг даргын Тамгын газрыг Засаг даргын өргөмжлөл 2,000,000 (Хоёр сая) төгрөгөөр, дэд байр эзэлсэн Дэлгэрцогт сумын Засаг даргын Тамгын газрыг Засаг даргын өргөмжлөл 1,500,000 (Нэг сая таван зуун мянга) төгрөгөөр тус тус шагнасугай.

4. Жилийн үйл ажиллагааны үр дүнгээр дутагдалтай үнэлэгдсэн Дэрэн, Өлзийт, Цагаандэлгэр, Хулд сумдад удирдамж гарган сум, байгууллагын үйл ажиллагаанд зөвлөн туслах ажлыг үр дүнтэй зохион байгуулж ажиллахыг Төрийн захиргааны удирдлагын хэлтэс (Н.Түвшинжаргал)-т даалгасугай.


4803100375

5. Тэргүүн байр эзэлсэн Эрдэнэдалай сумын Засаг даргын Тамгын газрын даргыг нэг сарын үндсэн цалин, дэд байр эзэлсэн Дэлгэрцогт сумын Засаг даргын тамгын газрын даргыг сарын үндсэн цалингийн 90 хувьтай тэнцэх хэмжээний мөнгөн урамшууллыг байгууллагын төсөвтөө багтаан шийдвэрлэхийг сумдын Засаг даргын тамгын газрын дарга, нягтлан бодогч нарт зөвшөөрсүгэй.

6. Үйл ажиллагааны үр дүнгээр 1, 2 дугаар байр эзэлсэн сумдын шагналд шаардагдах 3,639,000 (Гурван сая зургаан зуун гучин есөн мянга) төгрөгийг аймгийн Засаг даргын нөөцөөс гаргахыг аймгийн Засаг даргын Тамгын газар (Л.Доржбат), нягтлан бодогч (М.Янжиндолгор) нарт зөвшөөрсүгэй.

7. Сумдад өгсөн нийтлэг зөвлөмжийн хэрэгжилтийг хангуулах, холбогдох зөвлөмжийн хэрэгжилтийн явцад хяналт тавьж, зөвлөн тусалж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын хэлтсүүдэд даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.МӨНХБАТ

СУМЫН ЗАСАГ ДАРГА, ТҮҮНИЙ ТАМГЫН ГАЗРЫН 2022 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮНД ХИЙСЭН ХЯНАЛТ- ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ НЭГДСЭН ДҮН



Аймгийн Засаг даргын 2023 оны 1 дүгээр хавсралт өдрийн дугаар захирамжийн 1 дүгээр хавсралт

№	Сумын нэрс	Бодлогын баримт бичгийн хэрэгжилтийн үнэлгээ			Байгууллагын чиг үүргийн үзүүлэлтийн үнэлгээ				Байгууллагын нээлттэй байдлын үнэлгээ		Аймагас дэвшүүлсэн зорилт, тусгайлан оруулсан 9 асуудал	Дундаж	Ерөнхий үнэлгээ			
		Сумын Засаг даргын үйл ажиллагааны үнэлгээ	Аймгийн дэд хөтөлбөрийн хэрэгжилт	Эдийн засаг нийгмийн хөгжлийн үзүүлэлт	Дундаж	Аймгийн Засаг даргаас сумын Засаг даргатай байгуулсан	Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилт	Төрийн албан хаагчийн сургалт, нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийн	Үйл ажиллагааны үндсэн үзүүлэлтийн биелэлт	Дундаж				Мэдээллийн ил тод нээлттэй байдал	Төсөв, санхүүгийн үйл ажиллагаа, шилэн данс хөтөлөлтийн үнэлгээ	
1	САЙНЦАГАДАН	98.8	90	85.9	91.6	91.1	92.6	86.4	88.4	89.6	70	84.3	77.15	95.5	95.5	88.5
2	БАЯНЖАРГАЛАН	76.6	91.4	92.4	86.8	82.5	93.1	93.9	73.7	85.8	80	91.7	85.9	96.0	96.0	88.6
3	АДААЦАГ	77.3	84.1	91.0	84.1	87.0	89.6	88.8	68.8	83.6	85	90.3	87.7	75.0	75.0	82.6
4	ӨЛЗИЙТ	84.2	86.5	87.5	86.1	82.7	87.6	88.0	68.0	81.6	30	92.4	61.2	87.0	87.0	79.0
5	ДЭРЭН	88.6	81	78.0	82.5	84.4	68.6	85.9	84.6	80.9	10	89.2	49.6	83.5	83.5	74.1
6	ӨНДӨРШИЛ	90.1	89	88.6	89.2	85.1	93.9	93.8	83.4	89.1	40	92.7	66.35	85.0	85.0	82.4
7	ЭРДЭНЭДЛАЙ	88.3	97.5	96.0	93.9	89.0	87.5	92.7	90.2	89.9	95	90.9	93.0	94.0	94.0	92.7
8	ДЭЛГЭРЦОГТ	90.3	98.1	90.0	92.8	91.5	95.3	93.5	92.9	93.3	90	81.6	85.8	94.0	94.0	91.5
9	ЛУУС	88.5	77.5	92.0	86.0	87.9	88.7	91.6	83.5	87.9	50	88.7	69.4	77.0	77.0	80.1
10	ГОВЬ-УГТААЛ	77.5	90.4	84.2	84.0	81.2	89.3	90.5	75.3	84.1	90	84.7	87.4	73.5	73.5	82.2
11	САИХАН-ОВОО	94.6	98.0	86.0	92.9	86.3	89.5	91.5	85.7	88.3	40	90.3	65.2	89.0	89.0	83.8
12	ЦАГААНДЭЛГЭР	80	72.5	62.8	71.8	80.3	90.2	89.6	71.2	82.8	40	86.9	63.5	73.0	73.0	72.8
13	ГҮРВАНСАЙХАН	88	95.8	89.7	91.2	80.4	86.2	86.1	78.8	82.9	50	76.3	63.15	93.5	93.5	82.7
14	ДЭЛГЭРХАНГАЙ	86.6	92.5	89.9	89.7	88.8	94.1	90.5	79.9	88.3	50	90.1	70.1	82	82.0	82.5
15	ХУЛД	82.2	60	90.5	77.6	82.6	85.5	96.0	81.5	86.4	10	85.7	47.9	75	75.0	71.7
	ДҮН	86.1	87.0	87.0	86.7	85.4	88.8	90.6	80.4	86.3	55.3	87.7	71.5	84.9	84.9	82.3



СУМДАД НИЙТЛЭГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ЗӨВЛӨМЖ

1. Засгийн газрын 374 дүгээр тогтоолоор батлагдсан шалгуур үзүүлэлтийн дагуу мэдээллийг аймгийн сайтад 5 сарын 1-ний дотор багтаан бүрэн байршуулах.
2. Шилэн дансанд мэдээлэл оруулсан байдалд улирал бүр хяналт тавьж, хуулийн хэрэгжилтийг 100 хувь хангах
3. Тухайн онд хэрэгжүүлэх хөтөлбөр, хөтөлбөрийн үр дүнгийн талаарх мэдээллийг Сангийн яамнаас баталсан загвар маягт Хавсралт 1-ийн дагуу гаргаж, сумын ИТХ-аар батлуулан хэрэгжилт үр дүнг тооцож байх.
4. Өмч хамгаалах зөвлөлийн үйл ажиллагааг сайжруулан аймгийн ИТХТ-ийн 2020 оны 06 тогтоолын 2 дугаар хавсралтаар дагуу сумын өмч хамгаалах зөвлөлийн үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулан батлуулж, хэрэгжилт үр дүнг Орон нутгийн өмчийн газарт 6, 11 сарын 10-ны дотор тайлагнах.
5. Улс болон орон нутгийн татварын орлогын төлөвлөгөөг нэр төрлөөр нь сар бүр жигд биелүүлэх.
6. Цахим албан бичгийн дотоод үйл ажиллагааны цахимжуулалт, цахим албан хэрэг хөтлөлтийн тайланд улирал бүр дүгнэлт хийж, тайланг улирал бүрийн сүүлийн сарын 25-ны дотор Төрийн захиргааны удирдлагын хэлтэст цахимаар ирүүлэх.
7. Цахим хуудасны мэдээ мэдээллийг тогтмол шинэчилж, аймаг орон нутгийн мэдээллийг өөрийн албан ёсны фэйсбүүк хуудсаараа дамжуулан нийтэд түгээх, фэйж хуудасны хандалтын тоог нэмэгдүүлэх талаар тогтмол анхаарч үр дүнг сар бүр тооцон ажиллах.
8. Байгууллагын дотоод удирдлагын ERP системийн ашиглалтын сайжруулж, цаг бүртгэл, үүрэг даалгаврын цахим системд шилжиж, нийт албан хаагчдын цахим ур чадвар, тоон боловсролыг дээшлүүлэх.
9. Гадаад, дотоод сүлжээний зохион байгуулалт, интернэтийн хурдыг нэмэгдүүлэх замаар байгууллагын ERP болон төрийн сангийн системүүдийн хэвийн үйл ажиллагааг хангаж албан хаагчдын ажиллах нөхцөл боломжоор хангах.
10. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрх, оролцоог хангах сумын орон тооны бус дэд салбар зөвлөл болон Залуучуудын хөгжлийн зөвлөлийг сумын Засаг даргын захирамжаар байгуулан, төлөвлөгөө гарган батлуулж, тус зөвлөлүүдийн төлөвлөгөөг 4 сарын 15-ны дотор Нийгмийн бодлогын хэлтэст ирүүлэх
11. 0-17 насны хүүхдийн эрт илрүүлэг үзлэгийн хамрагдалтыг нэмэгдүүлэх.

12. Сумын нийт өрхийн 50-аас доошгүй хувийг угийн бичиг хөтлүүлэх ажлыг эрчимжүүлэх төлөвлөгөө гарган хэрэгжүүлж, үр дүнг Соёл, урлагийн газарт 6, 11 сарын 10-ны дотор тайлагнах.

13. Байгууллагын албан хаагчдын монгол бичгийн мэдлэгийн түвшнийг нэмэгдүүлэх ажлыг зохион байгуулж, явцын тайланг Нийгмийн бодлогын хэлтэст 6, 11 сарын 10-ны дотор ирүүлэх.

14. Эрх зүйн хөтчүүдийн үйл ажиллагааг тогтмолжуулан, судлан сурталчлах хууль эрх зүйн актын жагсаалтын дагуу улирал бүр 4-өөс доошгүй эрх зүйн сургалтыг иргэд, олон нийтэд зохион байгуулж тайланг улирал бүрийн сүүлийн сарын 25-ны дотор ХЭЗХ-т ирүүлэх

15. Аймгийн "Хүний нөөцийг хөгжүүлэх" дэд хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө гарган хэрэгжилтийг хагас бүтэн жилээр тооцож тайланг Төрийн захиргааны удирдлагын хэлтэст 6, 11 сарын 10-ны дотор тайлагнах.

16. Төрийн албаны тухай хуулийн 55.3-ын дагуу байгууллага бүр төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийг боловсруулан баталж, үр дүнг хагас бүтэн жилээр тооцож байх

ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ХЭЛТЭС